



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
АРВАЙХЭЭР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 02 сарын 05 өдөр

Дугаар 05

Арвайхээр

Зөвлөл шинэчлэн байгуулах
тухай

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 3.3, 3.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг дараахь бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай. Үүнд:

Зөвлөлийн дарга: О.Пүрэвдорж /Сумын Засаг дарга бөгөөд хотын Захирагч/

Нарийн бичгийн дарга: Б.Азжаргал /Засаг даргын Тамгын газрын Сум хөгжүүлэх сан хариуцсан мэргэжилтэн/

Гишүүдэд: Ц.Пүрэвсүрэн /Засаг даргын Тамгын газрын санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч/

Н.Алтанцэцэг /Жижиг, дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн/

Г.Шагдарсүрэн /Сум хариуцсан Улсын бүртгэгч/

М.Төрболд /Баялаг бүтээгчдийг дэмжих холбооны төлөөлөл/


Н.Сэдэд /Банкны төлөөлөл/

Д.Буянтогтох /Иргэний төлөөлөл/ 5 дугаар баг

М.Нэмэхбаяр /Иргэний төлөөлөл/ 13 дугаар баг

2. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагналтад хяналт тавьж ажиллахыг зөвлөлийн нарийн бичгийн дарга /Б.Азжаргал/-д үүрэг болгосугай.

3. Сумын ИТХурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 01 дүгээр сарын 13 өдрийн 03 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  Д.АМАРТҮВШИН